

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-5
<hr/>	
<i>1.Байнгын хорооны даргыг сонгох тухай</i>	3-4
<i>2.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай</i>	4-5

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны
03 дугаар сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 42 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Пүрэвдорж.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар, Ж.Эрдэнэбат.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Тогтохсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 10

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг Дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг сонгохыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулав.

Уг асуудлыг 09 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 09 цаг 57 минутад өндөрлөв.

Хуралдаан даргалсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Д.ТОГТОХСҮРЭН

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр,
Баасан гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 09 цаг 42 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Тогтохсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга өчигдөр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлыг удирдах чиглэлийг Улсын Их Хурлын даргаас надад хариуцуулсан. Тийм учраас Байнгын хорооны хуралдааныг даргалаад явуулах юм байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хурал нээснийг мэдэгдье.

Хуралд Занданшатар дарга, Оюунчимэг гишүүн, Ц.Мөнхцэцэг гишүүн, Сүхбаатар гишүүн, Баатарбилиг гишүүн, Батсуурь гишүүн, Адъяасүрэн гишүүн, Энхболд гишүүн, Бямбацогт гишүүн, Ганбаатар гишүүн гэсэн 11 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ингээд хуралдаанаа явуулъя. Хурлаар 2 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Байнгын хорооны даргын сонгогдох асуудал.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудал гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны даргын сонгох тухай асуудлаа хэлэлцье.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудалд нэр дэвшүүлэх нь Улсын Их Хурал дахь олонхын бүлэг буюу Монгол Ардын намын бүлгээс нэр дэвшүүлнэ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын нэрийг Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс нэр дэвшүүлж байгаа. Манай Байнгын хорооны гишүүд Энхболд гишүүнийг мэднэ. Улсын Их Хуралд 6 удаа сонгогдсон. Төрийн байгууллагын бүх л шатанд ажиллаж байсан. Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хэрэг эрхлэх газрын дарга, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга гээд бүх л шатад ажиллаж байсан төрийн ажлын дадлага, туршилагатай, Төрийн байгуулалтын байнгын хороог цаашид удирдаад авч явах туршилага, чадварыг нь үнэлж, Төрийн байгуулалтын байнгын хороон даргад нэр дэвшүүлж байгаа юм.

Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд та бүгдийг хэлэлцэн дэмжихийг хүсье. Ийм танилцуулга хийе. Ингээд нэр дэвшигч болон нэр дэвшүүлэлтээс асуух асуулттай гишүүд байна уу? Тэгвэл асуулт алга байна.

Үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Нямаагийн Энхболдыг нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 10 гишүүн буюу 90.9 хувийн саналаар Нямаагийн Энхболдыг Төрийн

байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэхийг дэмжиж байна. Адъяасүрэн гишүүн дэмжсэн байна, дэмжсэн байна. Тэгээд санал нь эсрэг гарсан юм байна. Тийм учраас дэмжсэнээр тооцож 100 хувийн саналаар дэмжсэн байна. Байнгын хороон даргыг сонгох асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны даргын санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хуралдаан даргалагч миний бие танилцуулах юм байна.

09.47 цаг

Хоёрдугаар асуудалдаа орё.
Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу дэд хорооны даргыг дотроосоо нэр дэвшүүлдэг. Ингээд олонхын саналаараа нэр дэвшүүлдэг ийм хуультай. Сая Улсын Их Хурлын халдашгүй байдлын дэд хороо хуралдсан. Энэ хуралдааны талаарх Улсын Их Хурлын Байнгын хороонд танилцуулах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Бямбацогт сайд танилцуулна. Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Сая Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасны дагуу байна. Тийм, өөр хүн байхгүй. Өөр нэр дэвших хүн алга байна.

Дэд хорооны даргад нэр дэвшүүлж дууслаа. Дэд хорооны даргад нэр дэвшигч Цэндийн Мөнх-Оргил гишүүнээс асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Халдашгүй байдлын дэд хороо хуралдаад Дэд хорооны даргыг Дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар дэмжинэ гэсэн хуулийн заалттай.

Энэ заалтын дагуу Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг дэвшүүлэхээр Халдашгүй байдлын дэд хорооноос оруулж байна. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд та бүхэн энэ асуудлыг хэлэлцсэн талаарх дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Тэгээд Цэндийн Мөнх-Оргил гишүүн маань бас хүрэлцэн ирсэн байна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ Байнгын хорооны тогтоол гарна. Дэд хорооны даргыг чөлөөлөөд, Дэд хорооны даргыг сонгосон ийм тогтоол гарах ёстой. Түрүүн хэлсэн, сая хэлсэн Энхболд дарга нэгдүгээрт Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга болж байгаа нөгөө талаас нь энэ Дэд хорооны дарга чинь Дэгийн хуулийн дагуу 1 жилийн хугацаатай юм байна лээ. Тэгээд хугацаа нь бас дууссан. Ийм учраас чөлөөлж оронд нь Мөнх-Оргил гишүүний нэрийг дэвшүүлж байгаа юм.

Дэд хорооны даргад өөр хүний нэр дэвшүүлэх саналтай гишүүд байна уу? Энэ чинь нөгөө 3 дотроосоо л явна шүү дээ. Хэрэв дэвшүүлбэл. Энэ чинь дэвших эрхтэй чинь одоо Бямбацогт гишүүн

Дэд хорооны даргыг хэлэлцэж байгааатай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Баярлалаа. Энэ саналыг бид нар нөгөө ил яриад байх бас хэцүү учраас. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаар сонгох нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 11 гишүүн буюу 91.7 хувь нь дэд хорооны даргыг сонгохыг, Мөнх-Оргилыг сонгохыг дэмжсэн байна. Байнгын хорооны тогтоол танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8, 28.9 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг сонгосугай.

2. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдыг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан даргалагч гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслөөс асууж, тодруулах саналтай гишүүд байна уу? Алга байна. Дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны оролцсон гишүүддээ баярлалаа.

09.57 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

